



КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ

**НИЙТИЙН ТӨВ**

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН АУДИТ ХИЙЛГЭХ,  
ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ



**pubcert.mn**



## Мэдээллийн аюулгүй байдлын аудит гэж юу вэ?

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.10-д заасанчлан "мэдээллийн аюулгүй байдлын аудит" гэж кибер аюулгүй байдлын хууль тогтоомж, холбогдох журам, стандартад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус хөндлөнгийн мэргэжлийн үйл ажиллагааг хэлнэ.



## Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хэрхэн хийлгэх вэ?

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9.1-д зааснаар мэдээллийн аюулгүй байдлын аудитыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэнэ. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн жагсаалтыг <https://mddc.gov.mn> цахим хуудаснаас авна уу.



### Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг ямар байгууллага хийлгэх вэ?

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1-д заасан Кибер орчинд дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1-д заасан хувийн хэвшлийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага

### Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх хуулийн хугацаа


Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1-д заасан хуулийн этгээд мэдээллийн аюулгүй байдлын аудитыг жил тутамд, холбогдох журамд заасан нөхцөл, байдал үссэн үед тухай бүр хийлгэх 2024 оны 08 дугаар сарын 18-ний дотор

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1-д заасан байгууллага мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд хийлгэх 2025 оны 08 дугаар сарын 18-ний дотор

### Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хаана ямар хугацаанд хүргүүлэх вэ?

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ний өдрийн А/74 дүгээр тушаалаар батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ийн 5.7-д зааснаар аудитын тайланг аудит хийлгэснээс хойш нэг сарын дотор Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвд хүргүүлнэ.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан хугацаанд олон улсын стандартын дагуу мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн бол тухайн аудитын тайланг үндэслэн энэ хуулийн 17.1.7, 19.2.6-д заасан үүргийг тус тус хангасанд тооцно.



## Хуулийн хэрэгжилт хангаагүй тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

Зөрчлийн тухай хуулийн

14.13.3. Эрх бүхий байгууллагын шаардсанаар мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, эсхүл хуульд заасан хугацаанд мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг холбогдох байгууллагад ирүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.13.6. Кибер аюулгүй байдлын талаар эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.